



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/75

Сүхбаатар сум

“Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн”
өдөрлөг зохион байгуулах, хөрөнгө гаргах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6.”а”, 30 дугаар зүйлийн 30.1.1, 39 дүгээр зүйлийн 39.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр батлах тухай” 233 дугаар тогтоолын 3.4, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.23 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын “Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил”-ийн хүрээнд Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн” сэдэвт өдөрлөг зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг сурталчлах, шинжээч бэлтгэх сургалт зохион байгуулахад шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сурталчлах, сургалт зохион байгуулахад шаардагдах 2.500.000 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг аймгийн хөтөлбөрийн хэрэгжилтийг зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.


3. Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн” сэдэвт өдөрлөгийг удирдамжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2019 оны 03-р сарын 15-ны өдрийн
А/75 тоот захирамжийн нэгдүгээр хавсралт



"Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн"
өдөрлөгийн удирдамж

Монгол Улсын Засгийн газрын "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил", Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын "Хариуцлагатай хэрэглээ-Хэрэглэгчийн эрхийн жил"-ийн хүрээнд Олон Улсын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн" сэдвийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулна. Үүнд:

1. "Аюулгүй, ухаалаг бараа, бүтээгдэхүүн" өдөрлөг зохион байгуулж иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сургалт, мэдээлэл хийх

2. Гарын авлага, плакат, шторк хийж орон нутгийн телевизээр нэвтрүүлэх зэргээр олон нийтийн нөлөөллийн ажлыг зохион байгуулах

3. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах сумын орон тооны бус зөвлөлөөс хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тайлангаа сумын иргэд, иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаа тайлагнах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, сурталчлах

4. Хэрэглэгчийн эрхийн хууль тогтоомжийг мэдээлж, сурталчлах, хяналт шалгалт хийх, арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллах

5. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах ажилд идэвх санаачлагатай ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүнийг шагнаж урамшуулах

Дээрх ажлуудыг зохион байгуулж, хийсэн ажлын тайлан мэдээгээ зурагжуулан 2019 оны 3 дугаар сарын 22-ны дотор ирүүлнэ үү.

Цахим хаяг: yondonjamts@selenge.gov.mn, selenge.afccp@gmail.com